



## Бурхан бол Энэрэнгүй Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

**Мөн чанар: Бурхан бол Энэрэнгүй**

**Attribute: God Is Compassionate**

**Тодорхойлолт:** Тэрээр халамжилдаг, хайрладаг, зовлон хуваалцдаг.

**Эшлэл(үүд):**

- **Дуулал 116:5** ЭЗЭН нигүүлсэнгүй ба зөвт Тийм ээ, бидний Бурхан өрөвч.
- **Дуулал 145:8-9** ЭЗЭН нигүүлсэнгүй хийгээд өршөөнгүй, уурлахдаа удаан, хайр энэрлээр аугаа их юм. Эзэн бүгдэд сайн. Түүний өршөөлүүд бүтээл бүхнийх нь дээр байна.
- **Гашуудал 3:22-23** ЭЗЭНий хайр энэрэл дуусдаггүй Өршөөл юунд нь төгсгөл үгүй. Өглөө бүр энэ нь цоо шинэ. Таны итгэлт байдал юутай аугаа вэ?
- **Иоел 2:13** Та нар хувцсаа биш, Харин зүрхээ урж тасчигтун” Бурхан Эзэндээ эргэгтүн, Учир нь Тэрээр нигүүлсэнгүй, өршөөнгүй. Уурлахдаа удаан, хайр энэрлээр бялхам, Шийтгэхдээ зөөлөрдөг.
- **Исаиа 30:18** ЭЗЭН та нарт нигүүлсэнгүй хандан хүлээж байна. Тиймээс та нарт өршөөл үзүүлэн өндөрт байж байна. Учир нь ЭЗЭН шударга ёсны Бурхан. Түүнийг хүлээгчид нь бүгдээрээ ерөөгдсөн ажээ!

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

*Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9*

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

**Өөрсдийн хүүхдүүдийн төлөө** — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

**Эшлэл(үүд):** Колоссай 3:12

**Библийн эшлэлээр залбирах:**

Бурханаар сонгогдсон ариун хийгээд хайрлагдсаны хувьд (Хүүхдийн нэр) өрөвч зүрх, энэрэл, даруу дөлгөөн зан, тэвчээрийг өмсөх болтугай.

**Залбирлын тодорхой хүсэлт**

**Багш/Ажилчид** (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та \_\_\_\_\_-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- Бурханаар сонгогдсон ариун хийгээд хайрлагдсаны хувьд \_\_\_\_\_ өрөвч зүрх, энэрэл, даруу дөлгөөн зан, тэвчээрийг өмсөх болтугай. *Колоссай 3:12*

**Сургуулийн төлөө залбирах** – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

**Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах** — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

*Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!*